



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 4360

Улаанбаатар хот

“Хавдрын эсрэг” арга хэмжээний
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хавдрын эсрэг” арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг нэгдүгээр, шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Л.Энхсайхан), Хавдар судлалын үндэсний төв (Н.Эрдэнэхүү), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Д.Нарантуяа)-д тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, гүйцэтгэлийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Хавдар судлалын үндэсний төв (Н.Эрдэнэхүү)-д ирүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
4. Дүгнэлт бүхий тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор тус яамны Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Л.Энхсайхан)-т ирүүлэхийг Хавдар судлалын үндэсний төв (Н.Эрдэнэхүү)-д үүрэг болгосугай.
5. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүр төсөвт тусган ажиллахыг Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар (Д.Нарантуяа)-т даалгасугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Ганцэцэг)-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД



“ХАВДРЫН ЭСРЭГ” АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗОРИЛГО

Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох тогтолцоог бүрдүүлэн, иргэдэд хүрэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

ЗОРИЛТ

1. Хавдрын хяналтын бодлого, эрх зүйн орчинг сайжруулах
2. Хүн амын дунд эрүүл мэндийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах
3. Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, оношилгооны үндэсний сүлжээг байгуулан, оношилгооны чадамжийг сайжруулах
4. Хавдрын оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
5. Хавдрын чиглэлээр нотолгоонд суурилсан эрдэм, шинжилгээ болон судалгааны ажлыг эрчимжүүлэх
6. Хорт хавдрын бүртгэл, тандалтын тогтолцоог бэхжүүлэх

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | 2021 | | 2022 | | 2023 | | 2024 | | Хариуцах байгууллага | Хамтрах байгууллага | Төсөв (сая) |
|---|---------------------------|--------------|--|--------------|--|--------------|--|--------------|--|----------------------|---------------------|-------------|
| | | Хүрэх үр дүн | | Хүрэх үр дүн | | Хүрэх үр дүн | | Хүрэх үр дүн | | | | |

ЗОРИЛТ 1.

Хавдрын хяналтын бодлого, эрхзүйн орчинг сайжруулах

Үйл ажиллагааны чиглэл 1.1.

Хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх, хянах үйл ажиллагааг бодлогоор дэмжих, хэрэгжилтэнд хяналт тавих

| | | | | | | | | |
|-------|--|---|--|--|--|-----------------|---|------------------|
| 1.1.1 | Хавдрын хяналтын урт хугацааны зорилтот хөтөлбөр (2022-2032)-ийг боловсруулан, батлуулах | Зорилтот хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах суурь үнэлгээ хийгдсэн байна | Хавдрын урт хугацааны зорилтот хөтөлбөр (2022-2032)-ийг боловсруулж батлуулсан байна | Хавдрын урт хугацааны зорилтот хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна | Хавдрын урт хугацааны зорилтот хөтөлбөрийн үйл ажиллагааны 10 хувийг | ЭМЯ ХСҮТ ЭХЭМҮТ | НЭМҮТ ХӨСҮТ Аймаг, Нийслэлийн ЭМГ ОУБ болон бусад | Улсын төсөв 50.0 |
|-------|--|---|--|--|--|-----------------|---|------------------|

| | | | | | | | | |
|-------|---|--|---|--|------------------------------------|----------------------|--|---------------------|
| 1.1.2 | Албан байгууллагууд ажилтнуудаа товлोलт хугацаанд хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдах хөшүүргийг бий болгох | Холбогдох эрхзүйн баримт гарах журамд өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан байна. | Ажил олгогч, эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл, Нийгмийн даатгал болон бусад төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг хийсэн байна | Холбогдох эрхзүйн баримт, бичгийг дагаж гарах журам батлуулсан байна. | хэрэгжүүлсэн байна. | ЭМЯ | НЭМҮТ ХСҮТ Холбогдох харъяа байгууллага уд ТББ | Улсын төсөв 20.0 |
| 1.1.3 | Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн төв болон нэгжийг байгуулах шийдвэр, эрх зүйн орчинг бүрдүүлэх | Эрт илрүүлгийн нэгжийн бүтэц, орон тоо, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар судалгаа гаргасан байна | Эрт илрүүлгийн төв, нэгжийн бүтэц, орон тоо, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан стандарт боловсруулсан байна | Эрт илрүүлгийн төв, нэгжийн бүтэц, орон тоо, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан стандарт батлуулсан байна | Стандартын хэрэгжилт эхэлсэн байна | ЭМЯ Сангийн яам ХСҮТ | СХЗГ Аймаг, Нийслэлийн ЭМГ | Улсын төсөв 60.0 |
| 1.1.4 | Хөхний хорт хавдрын удирдамж, гардан үйлдлийн стандартыг шинэчлэх | Удирдамж, стандартын төсөл боловсруулсан байна. | Шинэчлэгдэн батлагдсан байна | Шинээр батлагдсан удирдамж, стандарт хэрэгжиж эхэлсэн байна | | ЭМЯ ХСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ ОУБ болон бусад | Улсын төсөв 10.0 |
| 1.1.5 | Онко урологийн оношилгоо, эмчилгээний удирдамж батлах | Удирдамжийн төсөл боловсруулсан байна. | Удирдамж батлагдсан байна | Шинээр батлагдсан удирдамж хэрэгжиж эхэлсэн байна | | ЭМЯ ХСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ ОУБ болон бусад | Улсын төсөв 10.0 |

| | | | | | | | | |
|-------|--|---|--|--|---|-----------------|---|------------------|
| 1.1.6 | Хорт хавдрын хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний удирдамж, тушаал, зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах | Удирдамжийн төсөл боловсруулсан байна. | Удирдамж батлагдсан байна | Хэлэлцүүлэг хийгдэж, шийдвэр гарсан байна. | Аймаг, дүүргийн хавдрын тасгийн хөнгөвчлөх эмчилгээний орны тоог нэмэгдүүлэх тушаал гарсан байна. | ЭМЯ ХСҮТ ЭХЭМҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ Мэргэжлийн холбоод | Улсын төсөв 10.0 |
| 1.1.7 | Хорт хавдрын өвөрмөц тусламж үйлчилгээ (хими, хөнгөвчлөх, дуран) үзүүлж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх хууль эрхзүйн орчин бүрдүүлэх | Хөдөлмөрийн нөхцөлд өөрчлөлт оруулах төслийн санал боловсруулсан байна. | Төслийн саналаа ЭМЯ, ННХЯ-д өргөн мэдүүлсэн байна. | Хөдөлмөрийн нөхцөлд оруулсан өөрчлөлтийг НХХ-ийн сайдын тушаалаар баталж, эрх зүйн орчин бүрдсэн байна. | Дараах эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолто д өөрчлөлт рсон байна. -Химийн эмч, сувилагч, химийн эм найруулагч -Хөнгөвчлөхийн эмч, сувилагч, -Дурангийн эмч, сувилагч | ЭМЯ НХХЯ ХСҮТ | Үйлдвэрчний эвлэл Мэргэжлийн нийгэмлэг, холбоод | Улсын төсөв 5.0 |
| 1.1.8 | Хорт хавдрын үед эмнэлэг болон гэр бүлд үзүүлэх нийгэм, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх (Хүснэгт 1) | Хөтөлбөрийн үндэслэл боловсруулсан байна. | Насанд хүрэгчид болон хүүхдэд зориулсан 5 төрлийн тусламж үйлчилгээний удирдамжийг боловсруулж батлуулсан байна. | Удирдамжийг танилцуулах сургалтад ХСҮТ-ийн болон аймаг, дүүргийн эмч, нийгмийн ажилтнуудыг хамруулсан байна. | Хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээ хийгдэж зөвлөмж гарсан байна. | ХСҮТ ЭХЭМҮТ | ЭМЯ ХСҮТ СЭМҮТ | Улсын төсөв 90.0 |

| | | | | | | | | |
|-------|---|--|---|---|--|-----|---|-------|
| 1.1.9 | Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах | Тамхины хяналттай холбоотой нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулсан байна. | Олон төлөөллийг оролцуулсан хуулийн төслийг хэлэлцүүлэн, үзэл баримтлал боловсруулсан байна | Хуулийн төслийг Засгийн газарт өргөн барьсан байна. | Хууль дагаж гарах дүрэм, журмыг боловсруулан, батлуулсан байна | ЭМЯ | ХЗДХЯ Холбогдох яамд, харьяа байгууллага уд | ОУБ - |
|-------|---|--|---|---|--|-----|---|-------|

Үйл ажиллагааны чиглэл 1.2.
Үйлчлүүлэгчийн эрхзүйн орчинг сайжруулах

| | | | | | | | | |
|-------|--|---|--|---|--|-----------------------|---------------------------------|---------------------|
| 1.2.1 | “Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан хавдрын эрт илрүүлэг, шинжилгээ хийх товлолын жагсаалт”-ыг шинэчлэн батлуулах | ЭМС-ын 2017 оны А/420 тоот тушаалын хэрэгжилтийг үнэлэх | Товлолын жагсаалтыг шинэчлэн боловсруулах үндэслэл боловсруулсан байна | Товлолын жагсаалтыг шинэчлэн батлуулсан байна | Шинээр батлагдсан журам, стандарт хэрэгжиж эхэлсэн байна | ЭМЯ ЭМДЕГ НЭМҮТ | Холбогдох харьяа байгууллага уд | Улсын төсөв 20.0 |
| 1.2.2 | “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах журам”, “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц”-ыг шинэчлэх | | Журамын төсөл боловсруулсан байна | Журам шинэчлэгдэн батлагдсан байна | | ЭМЯ ЭМДЕГ НЭМҮТ | Холбогдох харьяа байгууллага уд | |
| 1.2.3 | Эрүүл мэндийн даатгалын сангийн жилийн төсвийн даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээний зардалд тусгагдсан төсөвтэй уялдуулан багц тодорхойлох | Тогтоолын үндэслэл боловсруулсан байна | Тогтоолын төсөл өргөн барьсан байна | Тогтоол шинэчлэгдэн, батлагдсан байна | Хэрэгжилт эхэлсэн байна | ЭМЯ ЭМДЕГ НЭМҮТ | Холбогдох харьяа байгууллага уд | Улсын төсөв 10.0 |

| | | | | | | | | |
|--|--|--|--|---|--|-------------------------------|--|-------------------|
| 1.2.4 | Умайн хүзүүний хорт хавдрыг үүсгэгч хүний папиллома вирусын эсрэг вакцинаар дархлаажуулах, хавдрыг бууруулах эрхгүйн орчинг бүрдүүлэх | Папиллома вирусын эсрэг вакцинаар хангах боломжийг судлах | Холбогдох эрхзүйн баримт, бичгийг дагаж гарах журам боловсруулан, арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан байна | Папиллома вирусын эсрэг вакциныг нийслэл, 7 аймагт нэвтрүүлсэн байна | Папиллома вирусын эсрэг вакциныг дархлаажуулал т эхлэх бэлтгэл ажил хангагдсан байна | ЭМЯ ХӨСҮТ | НЭМҮТ ХСҮТ Аймаг, Нийслэлийн ЭМГ | Улсын төсөв 10.0 |
| 1.2.5 | Умайн хүзүүний хорт хавдрын хүний папиллома вирусын эсрэг вакциныг үе шаттайгаар нэвтрүүлэх, шаардлагатай зардлыг улсын төсөвт тусгах талаар үйл ажиллагаа зохион байгуулах | Папиллома вирусын эсрэг вакциныг улсын төсөвт суулгах үндэслэл боловсруулсан байна | Дархлаажуулах үйл ажиллагааг төлөвлөх төсвийг батлуулсан байна | Папиллома вирусын эсрэг вакциныг дархлаажуулал т эхлэх бэлтгэл ажил хангагдсан байна | ЭМЯ ХӨСҮТ | ХСҮТ Аймаг, Нийслэлийн ЭМГ СЯ | Улсын төсөв 5.0 | |
| ЗОРИЛТ 2. | | | | | | | | |
| Хүн амын дунд эрүүл мэндийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах | | | | | | | | |
| Үйл ажиллагааны чиглэл 2.1. | | | | | | | | |
| Олон нийтэд хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ач холбогдлыг сурталчилан таниулж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх | | | | | | | | |
| 2.1.1 | Нийт хүн амд хавдрын эрт үеийн шинж тэмдэг болон анхдагч эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх асуудлаар мэдээлэл, сурталчилгааны нөлөөллийн цуврал интервенцийг сар бүр мэдээллийн хэрэгслээр тогтмол хийх | Хавдрын 7 төрлөөр цуврал контент хийж, хөтөлбөрийн төсөл боловсруулсан байна. | Мэдээлэл, сурталчилгааны цуврал интервенцийг сар бүр мэдээллийн хэрэгслээр тогтмолжуулж, иргэдийн мэдлэг, хандлага | Хавдраас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сурталчилгааны төрлүүд нэмэгдэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар | Зорилтот бүлэг тохирсон мэдээлэл, сурталчилгаа түгээгдэж, эрсдэлт хүчин зүйлийн талаар мэдлэг нэмэгдсэн байна. | ЭМЯ НЭМҮТ | ЭМХТ ХСҮТ ЭХЭМҮТ Аймаг, Нийслэлийн ЭМГ | Улсын төсөв 350.0 |

| | | | | | | |
|-------|--|---|---|--|--|---|
| 2.1.2 | <p>Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээл заагч багш нарыг хорт хавдраас урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн ач холбогдлыг чадавхижуулах сургалтын хөтөлбөр гаргаж, удирдамж боловсруулж нийслэлийн 3 дүүргийн эрүүл мэндийн багш нарын сургалтыг зохион байгуулсан байна.</p> | <p>Эрүүл мэндийн хичээл заагч багш нарыг хорт хавдраас урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн ач холбогдлыг чадавхижуулах сургалтыг хөтөлбөр гаргаж, удирдамж боловсруулж нийслэлийн 3 дүүргийн эрүүл мэндийн багш нарын сургалтыг зохион байгуулсан байна.</p> | <p>Эрүүл мэндийн хичээл заагч багш нарыг хорт хавдраас урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн ач холбогдлыг чадавхижуулах сургалтыг баруун, төв, хангайн бүсэд зохион байгуулж нийт 300 эрүүл мэндийн хичээл заагч багш нарыг хамруулсан байна.</p> | <p>Нийт Эрүүл мэндийн багш нарын дунд хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ач холбогдол, эрсдэлт хүчин зүйлийн улсын олимпиад зохион байгуулж, шалгарсан байгууллага, багшийн туршлага, арга зүйг нийтэд сурталчилсан байна.</p> | <p>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дундах зонхилон тохиолдох хорт хавдрын талаарх мэдлэг, хандлага, дэдлэг үнэлсэн байна</p> | <p>ЭМЯ БШУЯ НЭМҮТ ХСҮТ</p> <p>Аймаг, Нийслэлийн ЭМГ БСУГ</p> <p>Улсын төсөв 250.0</p> |
| 2.1.3 | <p>Хорт хавдрын эсрэг урьдчилан сэргийлэх ажилд оролцогч бусад салбар, байгууллагын оролцогчдод (Засаг дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн захирал, сургуулийн тогооч, оюутан, гоо сайханч, сэтгүүлч, хоол үйлдвэрлэгч) цуврал семинар зохион байгуулах.</p> | <p>Хавдрын эсрэг тэмцэхэд 300 ЕБС-ийн болон цэцэрлэгийн захирал нарыг оролцуулсан ухуулга нөлөөллийн ажил, семинар зохион байгуулсан байна.</p> | <p>Аймаг, дүүргийн 30 засаг дарга, нийгмийн бодлогын газрын даргыг оролцуулсан Хавдрын эсрэг ухуулга нөлөөлөл, семинарыг зохион байгуулсан байна.</p> | <p>Нийт 250 сургуулийн тогооч, хоол үйлдвэрлэгч нарыг оролцуулсан Хавдрын эсрэг семинар, ухуулга нөлөөллийн уулзалт зохион байгуулсан байна.</p> | <p>“Эрүүл аюулгүй- гоо сайхан” уриатай гоо сайханч, сэтгүүлч нарын төлөөллийг оролцуулсан ухуулга, нөлөөллийн семинарыг нийт 150 оролцогчдод зохион байгуулж, үр</p> | <p>ЭМЯ Аймаг, нийслэлийн ЭМГ</p> <p>НЭМҮТ</p> <p>290.0 сая</p> |

| | | | | | | | | |
|-------|--|--|--|--|---|-------------------------------|-------------------------------------|------------------------------|
| 2.1.4 | Хорт хавдрын хамгийн нийтлэг эрсдэлт хүчин зүйл болох шууд болон дам тамхидалтын тархалтыг бууруулахад чиглэсэн цуврал интервенцийг хэрэгжүүлэх | Нийт хүн амд чиглэсэн: - Тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэн хүний эрүүл мэнд, амь насанд учрах эрсдэл, хор нөлөөний талаар нэвтрүүлэг хийсэн байна -“Тамхигүй хот, аймаг, дүүрэг, орц” аян, хөдөлгөөн өрчүүлсэн байна. | Аж ахуйн нэгж, байгууллагад чиглэсэн: -“Тамхигүй байгууллага” шалгаруулах -Байгууллагын гадна талд стандарт хангасан “Тамхины цэг” байгуулсан байна. | Зорилтот бүлэг чиглэсэн: -“Тамхигүй сургууль” аян, -ЕБС, коллеж, их, дээд сургуульд “Үе тэнгийнхний сургагч багш” бэлтгэх сургалт зохион байгуулсан байна. | Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр тамхины эсрэг сайн үйлс (хот, дүүрэг, байгууллага, өрх) сурталчилсан байна. | ЭМЯ НЭМҮТ | ЭМХТ ХСҮТ | Улсын төсөв 150,0 |
| 2.1.5 | Хавдар үүсгэгч эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй (илчлэг өндөртэй, ханасан тос, транс тос, чихэр, давс ихтэй) хоол хүнс, зарим ундааны (согтууруулах) талаарх зар сурталчилгааг багасгах чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулах | СӨБ, ЕБС-ийн орчим худалдаж болохгүй хүнсний бүтээгдэхүүний талаар удирдлага, менежерүүдэд сургалт зохион байгуулсан байна. | Олон нийтийн хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөллүүдэд эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хүнсний бүтээгдэхүүний талаар ухуулга, нөлөөллийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. | Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөллүүдэд эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хүнсний бүтээгдэхүүний талаар ухуулга, нөлөөллийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. | Эрүүл зөв хүнсийг үйлдвэрлэсэн байгууллага, хамт олныг шалгаруулж, бүтээгдэхүүний г олон нийтэд сурталчилсан байна. | ЭМЯ БШУЯ ХХХХЯ НЭМҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ БСУГ | Улсын төсөв 10.0 185.0 |

| | | | | | | | | |
|-------|---|---|--|--|--|------------|-----------------------|---------------------|
| 2.1.6 | Хорт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэхэд хувь хүний үүрэг, оролцоог нэмэгдүүлэх (Хүснэгт 1) | Хорт хавдраас сэргийлэх “Эрт илрүүлгийн өврийн карт”-ын загвар боловсруулах | Эрт илрүүлгийн 3 нэгжид картыг нэвтрүүлж туршина. | Карт ашиглах талаар зорилтот бүлэгт чиглэсэн мэдээллээр хангасан. | Эрт илрүүлгийн картыг үндэсний хэмжээнд нэвтрүүлнэ. | ЭМЯ ХСУТ | ЭМХТ НЭМҮТ | Улсын төсөв 50.0 |
| 2.1.7 | Хавдрын даван туулагч болон асран халамжлагчдад зориулсан мэдээлэл сурталчилгааны материал боловсруулах, хэвлүүлэх, веб хөгжүүлэх (Хүснэгт 1) | Хавдрыг даван туулагчдад зориулсан гарын авлагыг боловсруулж, хэвлүүлсэн байна. | Мэдээлэл сурталчилгааны материал (гарын авлага, санамж, зөвлөмж) боловсруулж хэвлүүлсэн байна. | Вэб-д суурилсан гарын авлага, зөвлөмжүүдийг боловсруулж байршуулсан байна. | Мэдээлэл сурталчилгааны материалыг шинээр боловсруулж, хэвлүүлсэн байна. | ХСУТ НЭМҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ | Улсын төсөв 50.0 |

Үйл ажиллагааны чиглэл 2.2.

Хавдрын эсрэг үйл ажиллагаанд эрүүл мэндийн салбарын манлайлал, оролцоог нэмэгдүүлэх

| | | | | | | | | |
|-------|--|---|--|---|---|---------------------|-----------------------|---------------------|
| 2.2.1 | Үндэсний хэмжээнд “Эмч бүр хавдрын эсрэг хувь нэмрээ оруулья” Болзолт уралдааны аян өрнүүлэх, үр дүнг тооцож ажиллах | Аян зохион байгуулах удирдамж, заавар боловсруулсан байна. | Эрүүл мэндийн байгууллагуудад аян зохион байгуулах аяны заавар, журам удирдамж, батлаж хүргүүлсэн байна. | Аяныг тогтмол зохион байгуулж, манлайлсан байгууллага хамт олныг урамшуулж, олон нийтэд сурталчилсан байна. | Аяны үр дүнг тооцож, хэлэлцсэн байна. | ЭМЯ НЭМҮТ ХСУТ ЭМХТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ | Улсын төсөв 84.0 |
| 2.2.2 | ДЭМБ-ын “Тамхины эсрэг хувьсгал” хөдөлгөөнийг эрүүл мэндийн байгууллагад өрнүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын дотоод, гадаад орчныг тамхигүй орчин болгох | Эрүүл мэндийн байгууллагуудын дунд аян зохион байгуулах удирдамж батлаж хүргүүлсэн байна. | Аяныг тогтмол зохион байгуулж, манлайлсан байгууллага хамт олныг урамшуулж, олон нийтэд | Аяныг тогтмол зохион байгуулж, манлайлсан байгууллага хамт олныг урамшуулж, олон нийтэд | Аяны үр дүнг тооцож, үр дүнг хэлэлцсэн байна. | ЭМЯ НЭМҮТ ХСУТ ЭМХТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ | Улсын төсөв 50.0 |

| | | | | | | | |
|---------------------|---|--|---|--|----------|-------------|---------------------|
| Сурталчилсан байна. | Орон нутгийн засаг захиргааны оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хавдрын шалтгааны улмаас нас баралт хамгийн өндөр 3 аймгийг сонгон авч ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулсан байна | Хавдрын шалтгааны улмаас нас баралтыг бууруулсан тэргүүн туршлагыг нэвтрүүлж, жишиг аймгийг сурталчилан таниулах ажлыг зохион байгуулсан байна | Хавдар үүсгэх хүчин зүйлийг бууруулахад эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад ухуулга, нөлөөллийн үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулсан тэргүүн туршлагыг нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна | Тэргүүлсэн аймаг, орон нутгийг жил бүр олон нийтэд сурталчилж, үр дүнг танилцуулсан байна. | ЭМЯ ХСҮТ | Аймгийн ЭМГ | Улсын төсөв 50.0 |
|---------------------|---|--|---|--|----------|-------------|---------------------|

Талбар 2.3.

ХС/ХПВ/-ийн эсрэг вакциныг үе шаттай нэвтрүүлэх

| | | | | | | | |
|---|--|---|---|--|-----------|-------------------|----------------------|
| Бүтцийн хорт эсрэг ач иргэдэд ухуулга хэмжээг нарын байгуулах, бүтцийн хорт эсрэгэд эдгэсэн оролцуулсан ажлыг | Зорилтот 4 аймгийг сонгон УХХХ-аас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сурталчилгааны баримтын цомгийг ашиглан хэрэгжүүлж эхлэсэн байна. | Зорилтот 8 аймгийг сонгон УХХХ-аас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сурталчилгааны баримтын цомгийг ашиглан хэрэгжүүлж | УХХХ-ын эсрэг вакцины дархлаажуулалтыг шат дараалан нэвтрүүлсэн аймаг, орон нутгийн ухуулга, нөлөөллийн үйл ажиллагааг зохион | УХХХ-ын эсрэг вакцины дархлаажуулалтыг нэвтрүүлсэн аймаг, орон нутгийн ухуулга, нөлөөллийн үйл ажиллагааг 10 аймагт зохион | ЭМЯ НЭМҮТ | ХӨСҮТ ЭХЭМҮТ ХСҮТ | Улсын төсөв 125.0 |
|---|--|---|---|--|-----------|-------------------|----------------------|

| | | | | | | | |
|-------|---|--|--|---|---|----------------|----------------|
| 2.3.2 | Дархлаажуулалтын үеийн бэлтгэлийг ханган, явц болон нөхцөл байдалд дэмжлэгт хяналт хийх | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд үе шаттайгаар сургалт зохион байгуулах | Вакцинжуулах үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх | Вакциныг нэвтрүүлэх явцын үнэлгээг хийх | Вакцин нэвтрүүлсэний дараах үнэлгээг хийх | ЭМЯ ХСҮТ ХӨСҮТ | ЭМЯ ХСҮТ ХӨСҮТ |
| 2.3.3 | Умайн хүзүүний хорт хавдрын ХПВ-ийн эсрэг вакциныг үндэсний товлолд оруулсан байна | Эрүүл мэндийн болон бусад салбарын оролцоог хангасан ухуулга, нөлөөллийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна. | Вакциныг үндэсний товлолд нэвтрүүлэх үндэсний товлолд оруулсан байна | Хамрагдсан аймгийн тоо | | ЭМЯ ХӨСҮТ | ЭМЯ ХӨСҮТ |

ЗОРИЛТ 3.

Хорт хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээг байгуулан, оношилгооны чадамжийг сайжруулах

Үйл ажиллагааны чиглэл 3.1.

Хорт хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээг Хавдар судлалын үндэсний төвийг түшиглэн нэгдсэн удирдлагаар илрүүлгийн төв болон 21 аймаг, 9 дүүрэгт эрт илрүүлгийн нэгжийг байгуулах

| | | | | | | | |
|-------|---|--|--|---|-------------------------------------|-----------------|----------------|
| 3.1.1 | Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн төвийг байгуулах | Эрт илрүүлгийн төвийг байгуулах газрын асуудлыг шийдвэрлэх | -Техник эдийн засгийн үндэслэл боловсруулсан, -Барилгын зураг төсөл гарсан байна | Эрт илрүүлгийн төвийн үйл ажиллагаа эхэлсэн байна | Эрт илрүүлгийн хувь нэмэгдсэн байна | ЭМЯ Сангийн яам | ЭМЯ ХСҮТ ХӨСҮТ |
| 3.1.2 | Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн төвийг байгуулах | Эрт илрүүлгийн нэгжийг | Эрт илрүүлгийн нэгж байгуулах | 10 нэгжид мэргэжлийн | 21 нэгж улсын бүртгэлд | ЭМЯ | ЭМЯ ХСҮТ ХӨСҮТ |

| нэгжийг аймаг, нийслэлд үе шаттайгаар байгуулах | байгуулах газар, бүтэц орон тоо, төсөв, хэрэгжүүлэх үйл ажиллагааг торхойлсон байна | техникийн эдийн засгийн үндэслэл хийгдсэн байна | хяналтын байгууллагын дүгнэлт, шийдвэр гарсан байна. | бүртгүүлж, гэрчилгээгээ авсан байна. | Сангийн яам | Аймаг, Нийслэлийн ЭМГ | хөрөнгө оруулалтын зардал |
|--|---|---|---|--|-------------|--------------------------------------|---------------------------|
| 3.1.3 | “Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн төв”-д ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж чадавхижуулах <i>(Хүснэгт 2)</i> | -Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө гаргасан байна -Эрт илрүүлгийн төвд ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тоог гаргасан байна | Эрт илрүүлгийн төв эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан байна | Эрт илрүүлгийн хувь нэмэгдсэн байна | ЭМЯ ХСҮТ | НЭМҮТ ЭМХТ | Улсын төсөв 1,100.0 |
| 3.1.4 | “Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн нэгж”-д ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнийг үе шаттай сургаж чадавхижуулах <i>(Хүснэгт 3)</i> | -Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө гаргах -Сургалтын гарын авлага | 5 нэгжийн 90 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан байна | 15 нэгжийн 240 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | ЭМЯ ХСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ | Улсын төсөв 90.0 |
| 3.1.5 | Хавдрын эрт илрүүлгийн чанарын баталгаажилтын тогтолцоог бүрдүүлэх | Үнэлгээ хийх үйл ажиллагаа эхэлсэн байна | Эрхзүйн орчин бүрдсэн байна | Тушаал, журам гарсан байна | ЭМЯ ХСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ ЗДТГ ОУБ | Улсын төсөв 90.0 |
| Үйл ажиллагааны чиглэл 3.2. Хавдрын эрт оношилгооны чадамжийг дээшлүүлэх, орчин үеийн аргыг нэвтрүүлэх | | | | | | | |
| 3.2.1 | “Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн төв”-д хорт хавдрын эрт илрүүлэгт шаардлагатай | Шаардлагатай судалгаа, тоон мэдээллийг гаргасан байна. | Гарааны багцаар хангах байгууллагуудын сонгон шалгаруулалт | Төв нь 634015 зорилтот хүн амын гарааны багцаар | ЭМЯ ХСҮТ | Сангийн яам ЭМДЕГ | Улсын төсөв 3,066.0 |

| | Оношилгоо, эмчилгээний гарааны багцаар хангах (Хүснэгт 4,5) | | болон худалдан авалт хийгдсэн байна. | хангагдсан байна. | хувь нэмэгдсэн байна. | | |
|--|---|--|---|--|--|----------|---|
| 3.2.2 | “Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн нэгж”-д хорт хавдрын эрт илрүүлэгт шаардлагатай оношилгоо, эмчилгээний гарааны багцаар үе шаттайгаар хангах | Шаардлагатай судалгаа, тоон мэдээллийг гаргасан байна. | Гарааны багцаар хангах байгууллагуудын сонгон шалгаруулалт болон худалдан авалт хийгдсэн байна. | 10 нэгж нь 493120 зорилтот хүн амын гарааны багцаар хангагдсан байна. | 20 нэгж нь 986241 зорилтот хүн амын гарааны багцаар хангагдсан байна. | ЭМЯ ХСҮТ | Сангийн яам ЭМДЕГ Аймаг, Нийслэлийн ЭМГ |
| 3.2.3 | (Хүснэгт 4,5) Орон нутагт хавдрын тусламж үйлчилгээний зайн оношилгоо, эмчилгээг хүргэх хиймэл оюун ухаан дээр суурилсан телемедицинийг хөгжүүлэх | Хиймэл оюун ухаан дээр суурилсан телемедицинийг хөгжүүлэх төслийн санал боловсруулсан байна. | Хиймэл оюун ухаан дээр суурилсан телемедицинийг хөгжүүлэх орон нутгийн нөөц, бололцоог судлах | 10 аймаг, 1 дүүрэг Телемедицинийг ашиглан хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлдэг болсон байна | 11 аймаг, 8 дүүрэг Телемедицинийг ашиглан хавдрын тусламж, үйлчилгээний үндэсний сүлжээг бий болгоно | ЭМЯ ХСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ Улсын төсөв 100.0 |
| 3.2.4 | Хиймэл оюун ухаан дээр суурилсан телемедицинийг ашиглан мэргэжил, арга зүйгээр орон нутгийн эмч, мэргэжилтгүүдийг тогтмол хангах | IT нарыг чадавхижуулах | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө гарсан байна | Алсын зайн сургалт, зөвлөгөөнд хамруулсан тоо | Алсын зайн сургалт, зөвлөгөөнд хамруулсан тоо | ХСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ Улсын төсөв 100.0 |
| ЗОРИЛТ 4. Хавдрын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах | | | | | | | |
| Үйл ажиллагааны чиглэл 4.1 Хорт хавдрын өвөрмөц эмчилгээний тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, орон нутагт өргөжүүлэх | | | | | | | |

| | | | | | | | | |
|-------|--|---|--|--|---|----------|----------------------------|------------------------|
| 4.1.1 | Үндэсний хэмжээнд хөхний хорт хавдрын оношилгоо, эмчилгээ, нөхөн сэргээх мэс заслын тусламжийг цогцоор үзүүлж, сургалт, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий "Хөхний төв"-ийг байгуулах | Шаардлагатай хүний нөөц, багаж, тоног төхөөрөмж, хэрэгслийн судалгааг гаргах | -Хөхний төвийн кабинет байгуулсан, -Тус төвийн эмч, сувиллагч, техникч, лаборантыг сургаж чадавхижуулсан байна. | -Хөхний төв байгуулагдсан. -Хөхний мэргэжлийн хамтарсан баг бүрдсэн байна | Хөхний төвд үйлчлүүлэгчдийн тоо өссөн байна. | ЭМЯ ХСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ | Улсын төсөв 50.0 |
| 4.1.2 | "Хөхний төв"-ийг орчин үеийн Маммаграф болон ЭХО аппаратаар хангах | Тоног төхөөрөмжийн судалгаа хийх | -Төндөр зарлах -Худалдан авалтын баг ажиллах | Маммаграфи болон ЭХО аппарат суурилагдсан байна. | Хөхний хорт хавдрыг эрт оношилгоо, эмчилгээ нэмэгдсэн байна. | ЭМЯ ХСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ | Улсын төсөв 150.0 |
| 4.1.3 | Онко урологийн оношилгоо, эмчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлэх (Хүснэгт 6) | Үндэслэл боловсруулсан байна | Нэгж байгуулж, тоног төхөөрөмжөөр хангасан байна | Оношилгоо, эмчилгээний удирдамжийг баталсан байна. | Онко-урологийн оношилгоо, эмчилгээний төрөл нэмэгдсэн байна. | ЭМЯ ХСҮТ | УНТЭ Аймаг, Нийслэлийн ЭМГ | Улсын төсөв 400.0 |
| 4.1.4 | Баруун бүсэд туяа эмчилгээний салбар төв байгуулах төслийг хэрэгжүүлэх | -Техник эдийн засгийн үндэслэл боловсруулсан, -Барилгын зураг төсөл гарсан байна | Баруун бүсэд туяа эмчилгээний салбар төв байгуулсан байна. | Эмч мэргэжилтнийг ажлын байранд нь сургаж чадавхижуулсан байна. | Кобальт үүсгүүртэй аппаратаар хийгдэх зайн туяа эмчилгээг хийдэг болсон | ЭМЯ ХСҮТ | Баруун БОЭТ | Улсын төсөв 2,100.0 |
| 4.1.5 | Интерстициаль дотуур туяа эмчилгээг нэвтрүүлэх | Шаардлагатай хүний нөөц, багаж төхөөрөмж, багаж хэрэгслийн | Эмч мэргэжилтнийг ажлын байранд нь чадавхижуулсан байна | Эмэгтэйчүүдийн байрлалын хавдрын дотуур туяа эмчилгээг эхлүүлсэн байна | Хавдрын туяа эмчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн байна | ЭМЯ ХСҮТ | ЭХЭМҮТ Баруун БОЭТ | Улсын төсөв 1,100.0 |

| | | | | | | | | |
|-------|--|--------------------------|--|---|--|-----------------|-------------|----------------------|
| 4.1.6 | Орон нутагт хими эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх | судалгааг гаргасан байна | Аймаг, дүүргийн 30 нэгжийг ламинар боксоор хангана | -21 аймаг, 9 дүүрэгт хими эмчилгээ хийдэг болсон байна. | -Ажлын байрны давтан сургалт -Дэмжлэгт хяналт хийсэн байна | ЭМЯ ХСҮТ ЭХЭМҮТ | Баруун БОЭТ | Улсын төсөв 400.0 |
|-------|--|--------------------------|--|---|--|-----------------|-------------|----------------------|

Үйл ажиллагааны чиглэл 4.2

Хавдрын тусламж үйлчилгээний хүний нөөцийг чадавхижуулан, тусламж үйлчилгээг сайжруулах

| | | | | | | | | |
|-------|--|--|--|--|--|----------|----------------------------------|----------------------|
| 4.2.1 | Хавдрын даван туулагчдын хөтөлбөрийг хэрэгжүүлж эмнэлэгт болон хүн амд суурилсан даван туулагчдын сүлжээг байгуулсан байна. (Хүснэгт 1) | Даван туулагчдын хөтөлбөрийг боловсруулсан байна. | - Хавдрыг даван туулагч-Сайн дурын идэвхитний гарын авлага боловсруулж 500ш хэвлүүлсэн байна. - Даван туулагчдаас 40 хүнийг сайн дурын идэвхтэнээр бэлтгэж, гарын авлагаар 100% хангасан байна. | Бэлтгэгдсэн сайн дурын идэвхтэнүүд багадаа 200 хорт хавдартай иргэн, тэдний гэр бүлд хүрч үйлчилсэн байна. | Даван туулагч-СДИ-үүдийн үйл ажиллагаа тогтмолжиж хорт хавдартай 1000 иргэн, тэдний гэр бүлд хүрч үйлчилсэн байна. | ЭМЯ ХСҮТ | ДЭМБ Олон нийтийн оролцоотой ТББ | Улсын төсөв 130.0 |
